



ХЭНТИЙ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2021 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 23

Чингис хот

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот
Үйлдвэрийн газар байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 18 дугаар зүйлийн 18.1.3 /е/, /ж/, 20 дугаар зүйлийн 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 77 дугаар зүйлийн 77.2.4, 77.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хэнтий аймгийн хүн амыг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, төрөөс зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулах 1 850 000 000 /нэг тэрбум найман зуун тавин сая/ төгрөгийн дүрмийн сантай "Хэнтий орон сууц" нэртэй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг /ОНӨААТҮГ/ байгуулсугай.

2. "Хэнтий орон сууц" ОНӨААТҮГ-ын дүрмийг 1 дүгээр хавсралтаар, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. "Хэнтий орон сууц" ОНӨААТҮГ-г батлагдсан дүрмийн дагуу зохих баримт бичгийг бүрдүүлэн Улсын бүртгэлд бүртгүүлж, үйл ажиллагааг нь эхлүүлэн зохион байгуулах болон дүрмийн санг бүрдүүлэхэд шаардлагатай 1 850 000 000 /нэг тэрбум найман зуун тавин сая/ төгрөгийг орон нутгийн төсвөөс гарган санхүүжүүлэхийг аймгийн Засаг дарга /Ц.Идэрбат/-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв, хөрөнгө оруулалтын бодлогын хороо /Ц.Чинзориг/-д үүрэг болгосугай.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 23 дугаар сарын 31-ны
өдрийн 23 дугаар тогтоолын 02-р хавсралт

1 2 3
2 2
/ 2 ИТХ-ЫН ДАРГА

**"ХЭНТИЙ ОРОН СУУЦ" ОНӨААТҮГ-ЫН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга
Нарийн бичгийн дарга
мэргэжилтэн
Гишүүд

Аймгийн Засаг даргын орлогч ✓

СТСХ-ийн орлогын ✓

1. АИТХНБ-ийн дарга ✓

2. ХЭЗХ-ийн дарга ✓

3. СТСХ-ийн дарга ✓

4. ХОХБТХ-ийн дарга ✓

5. ОНӨГ-ын дарга ✓

6. ТББ-ын төлөөлөл

7. Иргэний төлөөлөл



**ХЭНГИЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХОРИН НЭГДҮГЭЭР ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 09

Чөлөөт хэлт

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хорин нэгдүгээр Хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. "Хэнтий-Ус" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Дарга:	Ж.Гантулга ✓	Аймгийн Засаг дарын Тамгын газрын дарга
Гишүүд:	Ү.Энх-Ариунаа ✓	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хяналт, дүн шинжилгээ, хууль эрх зүйн хэлтсийн дарга
	Э.Мөнх-Эрдэнэ ✓	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
	С.Нямдаваа ✓	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга
	Б.Дарханбаатар ✓	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга
	Г.Лхагвахатан ✓	Аймгийн орон нутгийн өмчийн газрын дарга
	Д.Бат-Эрдэнэ ✓	Хэрлэн сумын Засаг даргын орлогч
	Н.Ганболд ✓	Иргэний төлөөлөл /зөвлөх инженер/
	Ц.Чинзориг ✓	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хөгжлийн хорооны дарга
Нарийн бичгийн дарга:	Г.Батгэрэл ✓	"Хэнтий-Ус" ХХК-ийн гүйцэтгэх захирал

2. "Хэнтий-Ус" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийг удирдлага зохион байгуулалтаар ханган холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажиллаж, ажлын тайланг хагас жилд хороонд, жилийн эцэст аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Ж.Гантулга/-д үүрэг болгосугай.